



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сантмаргац сумын Засаг даргын тамгын газар-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/21/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p> <p>Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	3
3.1 Ерөнхий зүйл.....	3
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	3
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	3
3.4 Материаллаг байдал .....	4
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	4
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	4
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	5
3.8 Аудитын гол асуудал .....	5
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	5
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	6
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	6
4. Аудитын илрүүлэлт .....	6
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	7

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2022.02.15 № 1202/30

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

САНТМАРГАЦ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.СҮХБАТ-д

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сантмаргац сумын засаг даргын тамгын газар-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сантмаргац сумын засаг даргын тамгын газар-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013021891

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	13,366.39	14,439.49
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13,366.39	14,439.49
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	13,366.39	14,439.49
35410	Бичиг хэргийн материал	929.38	1,000.68
35420	Аж ахуйн материал	4,367.01	8,458.81
35470	Бусад хангамжийн материал	8,070.00	4,980.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	525,590.39	505,808.63
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	525,590.39	505,808.63
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	517,114.89	497,663.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	313,873.75	323,873.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,170.52)	(65,025.78)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	146,521.10	161,721.10
39204	Хуримтлагдсан элэгдэл	(103,643.18)	(106,802.14)
39205	Машин тоног төхөөрөмж	416,340.32	414,166.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(240,552.59)	(259,648.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,634.48	23,134.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,749.76)	(16,827.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	49,857.98	49,857.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,223.74)	(28,014.40)
39217	Ном	1,227.04	1,227.04
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,475.50	8,145.50
39301	Програм хангамж	3,302.00	3,302.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,344.50)	(1,674.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,518.00	6,518.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	538,956.77	520,248.11
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	116.22
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	116.22
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	116.22
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	116.22
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	538,956.77	520,131.89
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	538,956.77	520,131.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	398,404.86	398,404.86
51101	Өмч: - төрийн	398,404.86	398,404.86
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(178,196.75)	(197,021.63)
51210	Өмнөх үеийн үр дүн	(196,533.09)	(178,196.75)
51220	Тайлант үеийн үр дүн	18,336.34	(18,824.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	318,748.66	318,748.66
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	538,956.77	520,248.11

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	385,185.20	407,193.28
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	61,179.02	32,750.00
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	61,179.02	32,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,179.02	32,750.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61,179.02	32,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	324,006.18	374,443.28
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,142.48	12,914.38
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,914.38
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	320,863.70	361,528.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,863.70	361,528.90
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	366,848.86	426,018.16
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	366,848.86	426,018.16
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	341,150.94	356,356.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	188,654.56	186,639.55
210101	Үндсэн цалин	188,654.56	186,639.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,639.19	23,904.57
210201	Тэтгэврийн даатгал	16,230.52	16,464.05
210202	Тэтгэмжийн даатгал	1,909.48	1,965.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,524.22	1,504.57
210204	Ажилгүйдлийн даатгал	361.36	350.24
210205	Эрүүл мэндийн даатгал	3,613.62	3,620.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	54,928.28	55,122.74
210301	Гэрэл, цахилгаан	1,534.08	1,787.70
210302	Түлш, халаалт	53,394.20	53,335.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,059.49	19,976.10
210401	Бичиг хэрэг	1,993.15	2,862.00
210402	Тээвэр, шатахуун	11,467.54	13,722.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,598.80	2,452.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	938.70
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	4,780.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	4,780.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,868.00	2,760.00
210702	Дотоод албан томилолт	1,868.00	2,760.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,201.70	5,121.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,811.65	3,840.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	420.05	469.10

210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	201.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	349.90	203.40
210807	Газрын төлбөр	138.30	138.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	15.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,702.03</b>	<b>58,051.76</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,523.25	8,090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	180.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,875.38	49,781.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,697.92</b>	<b>69,661.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,922.10</b>	<b>48,644.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	48,644.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>21,017.46</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,017.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>18,336.34</b>	<b>(18,824.88)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>18,336.34</b>	<b>(18,824.88)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	398,404.86	318,748.66	(196,533.09)	520.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398.40	318.75	(196.53)	0.52
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	18,336.34	18.34
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.40	0.32	18.14	0.02
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.40	0.32	18.14	0.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.02	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	398,404.86	318,748.66	(178,196.75)	538.96
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398.40	318.75	(178.20)	0.54

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	324,006.18	374,443.28
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	324,006.18	374,443.28
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,142.48	12,914.38
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,914.38
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	320,863.70	361,528.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,863.70	361,528.90
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	319,356.18	374,443.28
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	319,356.18	374,443.28
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	293,658.26	304,781.82
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	188,464.88	186,523.34
210101	Үндсэн цалин	188,464.88	186,523.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,639.19	23,904.57
210201	Тэтгэврийн даатгал	16,230.52	16,464.06
210202	Тэтгэмжийн даатгал	1,909.48	1,965.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,524.22	1,504.57
210204	Ажилгүйдлийн даатгал	361.36	350.23
210205	Эрүүл мэндийн даатгал	3,613.62	3,620.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	54,928.28	55,122.74
210301	Гэрэл, цахилгаан	1,534.08	1,787.70
210302	Түлш, халаалт	53,394.20	53,335.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,957.46	18,783.90
210401	Бичиг хэрэг	2,565.53	2,857.70
210402	Тээвэр, шатахуун	10,793.13	13,473.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,598.80	2,452.70
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,097.70	1,097.70
210604	Урсгал засвар	1,097.70	1,097.70
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,868.00	2,760.00
210702	Дотоод албан томилолт	1,868.00	2,760.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,403.11	6,286.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,013.05	5,004.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	420.05	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	201.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.00	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	349.90	203.40

210807	Газрын төлбөр	138.30	138.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	15.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,299.65	10,303.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,996.25	10,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	25,697.92	69,661.46
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,922.10	48,644.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	48,644.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	21,017.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,017.46

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	308,884.80	340,521.44
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	308,884.80	340,521.44
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	308,884.80	291,877.44
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	200,810.90	186,523.34
210101	Үндсэн цалин	200,810.90	186,523.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,109.50	23,904.57
210201	Тэтгэврийн даатгал	19,077.00	16,464.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,008.10	1,965.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,606.50	1,504.57
210204	Ажилгүйдлийн даатгал	401.70	350.23
210205	Эрүүл мэндийн даатгал	4,016.20	3,620.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	55,181.90	55,122.74
210301	Гэрэл, цахилгаан	1,787.70	1,787.70
210302	Түлш, халаалт	53,394.20	53,335.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,524.10	15,783.90
210401	Бичиг хэрэг	2,857.70	2,857.70
210402	Тээвэр, шатахуун	10,473.50	10,473.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,192.90	2,452.70
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,097.70	1,097.70
210604	Урсгал засвар	1,097.70	1,097.70
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,797.20	2,760.00
210702	Дотоод албан томилолт	3,797.20	2,760.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,560.10	1,381.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	201.20
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.80	22.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	203.40
210807	Газрын төлбөр	138.30	138.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.70	15.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,803.40</b>	<b>5,303.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500.00	5,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	303.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	48,644.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	48,644.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	48,644.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	361,528.90
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	361,528.90
122005	Орон нутгийн төсвөөс	-	361,528.90

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	12,904.38
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	12,904.38
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	12,904.38
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	3,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	4,904.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,904.38
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	5,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	10.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	10.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	12,914.38
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	12,914.38
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,914.38

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сантмаргац сумын Засаг даргын тамгын газар-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа нар хэрэгжүүлсэн.

Сантмаргац сумын Засаг даргын тамгын газар-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 3/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сантмаргац сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ шударга ёсыг эрхэмлэн, намын харьяалалаас түдгэлзэж ил тод, ижил тэгш нээлттэй хөнгөн шуурхай хүргэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сантмаргац сумын Засаг даргын тамгын газар-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 426.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	13,366.3	14,439.4	1,073.1
Үндсэн хөрөнгө	525,590.3	505,808.6	19,781.70
<b>Нийт хөрөнгө</b>	<b>538,956.7</b>	<b>520,248.1</b>	<b>18,708.60</b>
Өр төлбөр	0	116.2	116.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	538,956.7	520,131.8	18,824.90
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>538,956.7</b>	<b>520,248.1</b>	<b>18,708.60</b>

Бараа материалын данс 1,073.1 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалыг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19,781.7 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 116.2 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүний орлогын албан татварын тооцооллоос үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 18,824.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 357,528.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 357,528.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 361,528.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 340,521.5 мянган төгрөгийг зарцуулж, 21,007.4 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 12,914.3 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг орлогыг бүрдүүлэн байгууллагын үйл ажиллагаанд 12,904.3 мянган төгрөгийг зарцуулж 10.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

## **3.8 Аудитын гол асуудал**

Нягтлан бодогч нь жолоочийн тооцоог бодохдоо шатахуун зарцуулалтын норм ашиглаагүй байна.

## **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн хязгаарлалттай дүгнэлт авсан бөгөөд нийт 4 төрлийн 61.9 мянган төгрөгийн алдаа зөрчил буюу 3 төрлийн зөвлөмж 1 албан шаардлагыг аьч бүгдийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын төсвийн зарцуулалтанд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.4 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийж гүйцэтгэсэн боловч нягтлан бодогч нь эд хариуцагчтай тооцоо бодоогүй байсан алдааг аудитын яюцад залрууллаа.

### 4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловрсуулан мөрдөөгүй 2.4 сая төгрөгийн шатахууны тооцооны хуудсыг эрх бүхий ажилтнууд хянаж баталгаажуулаагүй, шатахууны тооцоог бодохдоо шатахуун зарцуулалтын нормыг мөрдөөгүй;*

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөх*
- ✓ *Зам тээврийн сайдын 2019 оны 390-р тушаалын 2-р хавсралтыг мөрдөн ажиллах, автомашины үйлдвэрлэсэн огнооноос шалтгаалан тухайн автомашинд тохирох нормыг зааврын дагуу тогтоон мөрдөх*
- ✓ *Эд хариуцагч болон жолоочийн тооцоог хянах ажлыг сайжруулах, жолоочийн тооцоо бодож хэвших*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
1.	Сантмаргац сумын Засаг даргын тамгын газар	2	16.9	1	14.4					1	2.5
	Дүн	2	16.9	1	14.4					1	2.5